

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	С.Батдорж	Дугаар	L157
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Жаргалант
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Хамба лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Байдрагийн хийд	Сүм хийдийн дугаар	БХЖГ 089
Одоогийн сүм хийд	Эрдэнэ вангийн хийд	Сүм хийдийн дугаар	БХЖГ 022
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Байдраг сумын Байдрагийн хийд, Эрдэнэ вангийн хийд
 2007 оны 9 сарын 6-ны өдөр. Судалгааны баг Баянхонгор аймгийн Жаргалант суманд ирээд байна. **Ингээд тус**
 сумын төвд байх **Эрдэнэ вангийн** хийдийн хамба лам Сүүл овогтой Батдорж гуайтай үулзаад байна.
 Асуулт:-Та хийдийнхээ тухай танилцуулна уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Намайг Батдорж гэдэг, Сүүл гэдэг манай аавын нэр. Байдрагийн хүрээний хийд 1991-1992 онд **ашиглалтанд** орсон, шинээр баригдсан хийд. Манай аав ард түмний хандив дэмжлэг туслалцаагаар энийг босгосон.

Асуулт:-Анх энэ хийдийг үүсгэн байгуулсан хүмүүс ямар хүмүүс байдаг вэ?

Хариулт:-Манай хийд чинь 1939 онд Байдрагийн хүрээний хийд гэж, **Бяруузана** гэгээний хийд гэж манай энэ сумын төвөөс 16 км-ийн Мандал, Байдрагийн буурь, суурин дээр байдаг л даа, анх хуучин хийд нь.

Асуулт:-Энэ шинэ хийд?

Хариулт:-Энэ шинэ хийдийг манай аав Сүүл гэдэг хөгшин, өөр ард түмнээс манай Засаг дарга байсан Далантай, Баянхонгороос Халтар гээд, Жадамбаа гээд хөгшин хүн байсан, тэр хоёр хүмүүс Баянхонгороос хүмүүс авчирч байж энэ хийдийг босгосон. Хуучны зураг төслөөр барьж босгосон л доо.

Асуулт:-Анх шинээр сэргээгдэж байгуулагдах үед хичнээн тооны ламтай, ямар ном хурдаг байсан бэ?

Хариулт:-Манайх анх 1994 онд **ашиглалтанд** ороход хөгшчүүл их олон байсан л даа, 8 хөгшин байсан. Жадамбаа, Самбуу, манай аав, Баттулга гэж лам, Санжаасүрэн, Мөнхбаяр, би өөрөө байсан.

Асуулт:-Тухайн үед ловон нь хэн байсан бэ?

Хариулт:-Ловон лам нь аав байсан. **Гэсгүй** нь болохоор Баттулга гэж хүн байсан л даа, **унзад** тэр үед байгаагүй.

Асуулт:-Анх үүсгэн байгуулагдах үедээ ямар аль урсгалаар хурал номоо хурдаг вэ?

Хариулт:-Одоо манайх яг урсгалаараа гэх юм бол уг нь анхныхаа тэр юугаар бол 10 **хангал**, Цогчэн хурдаг байсан, одоо хөгшчүүл бүгд их цөөрөөд, одоо шашныхаа юуг Цогчэн уншлагаараа л явж байна даа.

Асуулт:- Хурал номын хувьд?

Хариулт:-Манайх сарын 15, 25, 29-нд хурлаа хурж байна, шинийн 8-нд хурж байна. Бусад өдрүүддээ яг хурсан юм алга байна л даа.

Асуулт:-Сүсэгтэн олны захиалгаар хурдаг уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-1994 онд байгуулагдсанаас хойш гол томоохон үйл явдал хийдийн түүхэнд тэмдэглэгдэхээр үйл явдал юуг нэрлэж болох вэ? Жишээлбэл, лам нар суралцуулахаар явуулсан гэдэг юмуу, эсвэл томоохон хутагт хувилгаад морилж ирсэн ч гэдэг юмуу?

Хариулт:-Түүхэнд тэмдэглэгдэхээр Маралын хүрээний хийдийн Жадамбаа гэсэн их **гэсгүй** гэгээн хүн ирсэн. Маралын хүрээний хийдийн том лам. Манайхаар орж буугаад явсан. Тэрнээс хойш саяхан Отгонтэнгэр уулын **тахилганд** хамба лам Чойжамц гуай өөрөө хоёр шавьтайгаа ирж манай хийдээр ороод уулзаад явсан л даа. Буцахдаа энүүгээр хурал, зөвлөгөө хийгээд явъя гээд чадсангүй. Шөнөдөө яаруу явна лээ.

Асуулт:-Танайхаас шавь нараас чинь сурч байгаа шашны сургуульд сурч байгаа тийм юм байна уу?

Хариулт:-Одоо бол яг явуулсан юм байхгүй л дээ. Баянхонгорт манай нэг лам байна, их **гэсгүй хийж байгаа**, манайхны хийдэд сууж байсан манай аавын шавь л даа. **Ишгомбо** гэж лам байгаа.

Асуулт:-Одоогийн байдлаар хийдийн лам нарын тоо хэд байна?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-5, 6 лам байна.

Асуулт:-Тус Байдраг сумын нутагт байсан **Эрдэнэ вангийн** хүрээний тухай, түүхэн газрын тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Манай Байдрагийн хүрээний хийдийн **Сайн ноён** хаан аймгийн **Эрдэнэ засаг** вангийн ноён хүн байсан байна л даа. Гол хийд болох Байдрагийн хүрээ гэж манай Жаргалант сумын хуучны төвөөс 16 км, хуучин **Мандал байдраг** гэсэн голын бэлчээр дээр байдаг. 1820 онд баригдсан юм байна. 1930 онд эвдэрч сүйдсэн. Одоо зөвхөн туурь балгас нь байдаг л даа. Эсэргүүний үеэр Мандалын урд дээрээс буудаж устгасан тийм юу байна лээ. Уг нь их сайхан бүгдээрээ байж байж л. Эсэргүүний үеэр лам нарын юу баригдаад тэгээд устгал хийсэн юм билээ. Мандалын юун дээрээс үхэр буугаар буудаж яасан юм билээ. Манай дуган бол хуучны юугаараа бол 17 дугантай, 11 жастай, 400 орчим ламтай. Өвгөн **чойр** хэмээх улаан дуганууд байсан байна. Их том дуган байсан даг. Цагаан дуган, Тосгон дуган гээд их олон дуган байсан. Энд манай гол хийдийн гол шүтээн нь Махгал бурхан.

Асуулт:-Одоо энэ шинэ хийдийнх ч гэсэн адилхан уу?

Хариулт:-Манайх ч гэсэн адилхан бид **махгал бурханаа** шүтэж байгаа. 10 **хангал** хурдаг байсан тэр үед. Тэгээд 400гаруй лам 3 давхар байшин,их том олон жастай. Манайхаас чинь Архангай, Гурванбулаг, **Баянбулаг** чинь манайх дээр бүгд л харьяалагдаж байсан, Дарь эхийн жас, Бууцагаан гэж байна. Манайх Дарь эхийн жас бүгд манайх дээр их хурал, хойноосоо Архангай, урдаасаа **мандалынхан** ирж ингэж хурал хурдаг дээр үеийн тийм том газар байсан гэж хөгшчүүл ярьдаг байсан даа. Аваас авахуулаад.

Асуулт:-Майдар эргэдэг байсан уу?

Хариулт:-Манайх **Майдар** эргэдэг байсан, хуучны хөгшчүүлийн ярьж байгаагаар **Майдар** хөх морь унасан тийм сайхан их гоё **Майдар** эргэж Галуутын Мандалын хүрээ бий шүү дээ,тэнд их ногоон морины чуулга хурж, эндээс явж тэнд **Майдар** эргэдэг байсан байна л даа.

Асуулт:-Цам хийх үү?

Хариулт:-Цам **Майдарын** хувьд адилхан шүү дээ. Бүгдээрээ цам **Майдар** чинь бүгд ороод явчихна. Бүтээлийн дуганы үед бар ирвэс, баавгайн арьс, бугын ясан эвэр, сайн бөхийн зодог шуудаг, **бурханы** хөлөг, үхэр оготнын баримал зэрэг урлагийн нэрт үзвэр их байсан байна л даа, тэр үед бол. Гол шүтээн нь болохоор Махгал бурхан гэж байсан, 10 **хангалын** нэг тахидаг. Манай хошууны гол шүтээний нэг нь дуудах нэрийг ихэд цээрлэдэг учир **махгал** бурхан гэж заншсан л даа. Бяруузана гэгээний хувилгаан гэдэг ламын үе залгамжилж байсан байна л даа. Одоо тэр хийдийн хамба.

Асуулт:-**Бяруузаны** хойд дүр гээд тодруулаад байдаг?

Хариулт:-Тийм. Тэр хүн чинь хамгийн сүүлчийн хувилгаан хүн байсан. Энэ хүн болохоор Юм бэйсийн хошууны Соном гэгчийн хүү Лувсандаш гэж хүн байсан.

Асуулт:-Энэ сүүлийнх нь хувилгаан байх нь байна шүү дээ?

Хариулт:-Сүүлийнх нь дүр нь Юм бэйсийн хошууны Соном гэгчийн хүү Лувсандаш гэдэг хүн байж л дээ. Сүүлчийн хувилгаан нь их хэлмэгдсэн. Тэгээд **зугатан** Хөвсгөл, Булган хил орчмоор хил гарч Буриадын нутагт

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

амьдарч байгаад 1975-1976 онд нас барсан юм байна лээ. Сүүлчийн хувилгаан нь ээж, ах нар нь одоо хүртэл байдаг юм шүү дээ.

Асуулт:-Хэн хэн гэж хүмүүс байх вэ?

Хариулт:-Говь-Алтай аймагт байдаг юм.

Асуулт:-Архангайн Чулуут суманд бас байдаг үү?

Хариулт:-Архангайн Чулуут суманд бас сум нь хойноосоо орж ирж цуг нийлж хурал чуулган хийдэг. Тэр хүн болохоор эсэргүүний үеэр хойгуур дамжигдаж явсаар байгаад Архангайн Чулуутад суурьшиж байсан. Лувсандашийн үр удмууд нь амьд сэрүүн байгаа юм байна л даа. Зарим хүмүүс нь Ойдов, Дүвчин гэдэг. Говь-Алтай аймагт одоо энэ хүмүүс байдаг юм. Ойдов гуай өөрөө өнгөрчихсөн. Хамгийн сүүлчийн хувилгаан өргөмжлөгдсөн. Говь-Алтай аймгийн **тууварчин**.

Асуулт:-Тэрнийг хүмүүс зөвшөөрдөг юмуу?

Хариулт:-Хуучны улс зөвшөөрдөг юм. Энэ хүрээний хийдийн сүүлчийн их унзад. Хувилгаан хүн байсан. Говь-Алтай аймагт Ойдов гэж хүн байх ёстой. Үр удмууд нь Хаянхярваа гэж лам хотод байж байгаад **37-тойдоо** өнгөрлөө. Байдрагийн хүрээний хийдэд байсан л даа, хүүхэд нь гэгээн бас тийм байсан.

Хүрээний сүүлчийн их унзад нь манай нутагт хүндлэгдэж бишрэгдэж хүлээж байсан Цагаан гавж гэж авгайлан нэр нь, Цагаан Цэгмид гэдэг хүн байсан байна. Бяруузана хүрээний сүйтгүүлж, дараа нь үүрэгтэй хэлмэгдээд, ялаар шийтгүүлж зовлонгийн туйлыг давж гарч ирсэн сүүлчийн цөөхөн хэдхэн гавж хүний 60, 70, 80 онд тусгаарлуулсан байна л даа.

Асуулт:-**Үүнд** ямар ямар хүмүүс байсан гэнээ?

Хариулт:-Үүнд жишээ нь, Балжинням, Баянжаргал гавж хүн байсан байна, Бүжингийн **Санжила** гэж хүн, Мөнхийн Цэнд, Цанжид гавж байна, Буянцогтын Энэбиш гавж, Энэбиш гавж аавын өөрийнх нь жинхэнэ гарынх нь багш л даа. Хадны гавж гэдэг юм. Энэ нь саяхан ч шашны сүмийнхэн байж байгаад үхсэн хүн л дээ, Энэбиш **гавж** гэж. Үр хүүхдүүд нь энд байдаг юм.

Цагаан Цэгмид гэж гавж байна. Түрүүний ярьдаг. Лувсандагвын Энэбиш гэж бас байна. Гомбын Магсар гэсэн ийм дүрүүдтэй, нутгийн улсынхаа сэтгэл зүрхэнд үлдэж байдаг юм байна. Зуны адаг сарын шинийн 8-нд **Майдар** эргэнэ. Наадам хийдэг. Хохимой, Намсрай, балин шашин, **Махгал, Дамдинчойжоо** зэрэг **бурхад**ын цагаан өвгөн, буга, согоо, хашин, хангарьд, бүрээ бишгүүрүүд тийм байна. Цан хэнгэрэг, сэлэм, ганлин гэдэг нь **жод, лүйжин** тавьдгийн ганлин бий шүү дээ, лимбэ зэрэг хөгжмүүд байсан байна л даа. Хөгжмийн зэмсгүүд гэсэн үг л дээ. Хамгийн сүүлд гүзээ хэмээх Баянжаргал гавж **Чинбон** Дэлэг ч гэж байсан энэ хүний үр удам одоо Заг сумын төвд сайн сайхан амьдарч байгаа юм байна л даа. Майдарын үеэр мөргөлчид, **Ганжуур Данжуур** үүрэн хүрээг тойрдог байжээ.

1990-ээд оноос Байдрагийн хийдийг сэргээх бүяны үйлст хуучин хийд байсан суурин дээр суварга босгосон. Энэ хуучин хүрээний хийдийн суурин дээр манай аав Сүүл гэдэг хөгшин Бяруузана гэгээн багшийнхаа даалгавраар Байдрагийн хүрээний хийдэд хамгийн сүүлд Сүүл гэдэг хүн ч л энэ хийдийн хамгийн сүүлийг мушгиж ч энэ

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хийдийг босгоно. Тийм учраас багшийнхаа захиасын дагуу би өөрөө энэ Байдрагийн хүрээний хийд дээр суварга босгоё гэж очиж гэр барьж тэндээ өөрөө хувиараа барьсан л даа. Хэдэн хүүхдүүдтэйгээ нийлж манай аав өөрөө босгож, аав багшийнхаа захиасыг биелүүлнэ гэж хэлсэн. Тэгээд тэрнийгээ биелүүлсэн. Тэгээд энд сумынхаа төвд бас энэ Байдрагийн хүрээний хийдийг босголоо. Яг хуучин зураг төслөөр нь аймгаас хүмүүс авчирч ард түмэнтэйгээ нийлж, Энэ сайхан хийдээ одоо хүртэл байгуулсан хийд нь ард түмэндээ хурал номоо хийж, үр хүүхэд нь залгамжлаад байж байна л даа.